

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ,
“МОНГОЛЫН ТЭЭВЭР ЗУУЧЛАГЧДЫН НЭГДСЭН ХОЛБОО”
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА ХООРОНД ХАМТЫН АЖИЛЛАГАА
ӨРНҮҮЛЭХ ТУХАЙ ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН
САНАМЖ БИЧИГ

2015 оны 2 дугаар
сарын 24-ны өдөр

Дугаар 244

Улаанбаатар хот

Монгол Улсын Зам, тээврийн яам болон “Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо” төрийн бус байгууллага /цаашид хамтад нь “Талууд” гэх/;

Монгол Улсын тээврийн салбар дахь тээвэр зуучлалын /агаарын тээврийн зуучлал, төмөр замын тээвэр зуучлал, авто тээврийн зуучлал, далайн тээврийн зуучлал/ үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх, тээвэр зуучлалын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор дор дурьдсан чиглэлээр хамтран ажиллахаар харилцан ойлголцож, энэхүү санамж бичгийг байгуулав. Үүнд:

1-р зүйл

Зам, тээврийн салбарт тээвэр зуучлалын үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:

- 1.1. Тээвэр зуучлалын олон улсын туршлага, эрх зүйн зохицуулалтыг судалж шаардлагатай баримт бичгийг шинээр боловсруулах болон одоо мөрдөгдөж буй баримт бичгийг шинэчлэн сайжруулах талаар холбогдох хууль, дүрэм, журмын төслийн талаар санал солилцох;
- 1.2. Тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага, хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр хамтран ажиллах;
- 1.3. Монгол Улсын тээвэр логистикийн салбар хөгжүүлэхтэй холбоотой асуудлаар тээвэр зуучлалын байгууллагын саналыг тусгах, харилцан дэмжлэг үзүүлэх.

2-р зүйл

Монгол Улсын экспорт, импорт, дамжин өнгөрөх тээвэр хөгжүүлэх чиглэлээр:

- 2.1. Ачаа, барааг улсын хилээр нэвтрүүлэх үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагуудад хууль ёсны дагуу санал тавих;
- 2.2. Монгол Улсаар дамжин өнгөрөх тээврийн хэмжээг нэмэгдүүлэх, давуу талаа таниулан сурталчлах зорилгоор “Транзит Монгол” үндэсний хөтөлбөр

хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх, нэмэгдүүлэх, үндэсний болон олон улсын чанартай уулзалтыг харилцан тохиролцсоны үндсэн дээр хамтран зохион байгуулах;

- 2.3. Ачаа, тээврийн төрөл тус бүрээр, статистик тоон мэдээлэл, бусад судалгаа, тооцоо гаргах талаар харилцан мэдээлэл солилцох;
- 2.4. Монгол Улсын гадаад улстай байгуулсан хоёр талт болон олон талт гэрээ хэлэлцээрүүдийг сайжруулах чиглэлээр санал боловсруулах;
- 2.5. Өмчийн хэлбэр, тээврийн төрлүүдээс үл хамааран тээврийн байгууллагууд хоорондын харилцан уялдаа холбоо хамтын ажиллагааг бэхжүүлэх;
- 2.6. Далайн тээврийн талаар хамтран ажиллаж, олон улсын гэрээ хэлэлцээр, конвенци, протоколуудыг сурталчлан таниулах, шинээр гарсан өөрчлөлт, дүрэм, журам, зөвлөмжүүдийг цаг тухайд нь харилцан мэдээлэх;
- 2.7. Нэгдсэн тээвэр хөгжүүлэх чиглэлээр баримталж байгаа бодлого, үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллах;
- 2.8. Тээврийн чиглэлээр зохион байгуулагдаж буй олон улсын чанартай аливаа үйл ажиллагааны талаарх мэдээллийг харилцан солилцох.

3-р зүйл

Тээврийн салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр:

- 3.1. Тээврийн салбарын чиглэлээр суралцаж буй оюутнуудад “Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоон” ТББ-аас санхүүгийн болон бусад тусламж үзүүлэх, Зам, тээврийн яамнаас мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх, тэдгээрийг дэмжиж ажиллах;
- 3.2. Тээврийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх чиглэлээр сургалт зохион байгуулахад харилцан дэмжлэг үзүүлэх.

4-р зүйл

Төмөр замын тээвэр зуучийн гэрчилгээжүүлэлтийн чиглэлээр:

- 4.1. Тээвэр зуучлалын салбарын гэрчилгээжүүлэлтийн чиглэлээр холбогдох стандарт, шаардлага боловсруулахад хамтран ажиллах;
- 4.2. “Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо” ТББ нь төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ хүсэгч хуулийн этгээдэд тавигдах шаардлагын дагуух баримт бичгийн бүрдүүлэлтийг хянаж, хамтран ажиллах;

5-р зүйл

1. Санамж бичиг нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд 3 жилийн хугацаатай байна.
2. Талууд санамж бичгийн хүчинтэй байх хугацаанд санамж бичгийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэж цаашид анх байгуулсан санамж бичгийн хугацаатай ижил хугацаанд сунгаж болно.

Энэхүү санамж бичгийг 2015 оны 2 дугаар сарын 04-ны өдөр 2 хувь үйлдэв.



САНАМЖ БИЧГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ПРОТОКОЛ

2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

Зам, тээврийн яам, “Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо” төрийн бус байгууллага хооронд 2015 оны 12 дугаар сарын 04-ны өдөр байгуулсан 244 дугаартай “Хамтын ажиллагаа өрнүүлэх тухай харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн 4.2. дахь заалтыг үндэслэн, MNS5523:2013 дугаартай “Тээвэр зуучлал. Ерөнхий шаардлага” стандартын 7.1.-т “...Тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдийг үйл ажиллагаа эрхлэх нөхцөл боломж бүрдүүлсэн байдал, үйлчлэх хүрээ, хүчин чадал, санхүүгийн чадавхаар нь тээвэр зуучлалын мэргэжлийн холбооноос гаргасан саналыг авч, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэрчилгээжүүлнэ.” гэснийг хэрэгжүүлэх зорилгоор, Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, “Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо” төрийн бус байгууллага дараах зүйлсийг харилцан тохиролцов. Үүнд:

1. Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо нь төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагааны гэрчилгээ хүсэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын баримт бичгийг хүлээн авч, Зам, тээврийн сайдын 2012 оны 120 дугаар тушаалаар батлагдаж Улсын нэгдсэн бүртгэлийн 2013 оны 3360 дугаарт бүртгэгдсэн “Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журам”, түүнчлэн MNS5523:2013 дугаартай “Тээвэр зуучлал. Ерөнхий шаардлага” стандартын дагуу бүрдлийг хянаж, зөвлөгөө өгөх, бүрдсэн баримт бичгийг гэрчилгээжүүлэх ажлын хэсгийн хуралд оруулахаар Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт бэлтгэж ирүүлж байх.
2. Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо нь олгогдсон гэрчилгээг бүртгэж, тухайн аж ахуйн нэгж байгууллагад дамжуулж өгнө. Мөн гэрчилгээ олгогдоогүй аж ахуйн нэгжүүдэд ажлын хэсгийн дүгнэлт тайлбарыг уламжилна.
3. Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагааны гэрчилгээ хүсэгчийн баримт бичгийг хүлээн авахдаа эрх тэгш, ялгаварлахгүй, ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй байх зарчмыг баримтлан ажиллана.
4. Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо нь Зам, тээврийн сайдын 2012 оны 120 дугаар тушаалаар батлагдаж Улсын нэгдсэн бүртгэлийн 2013

оны 3360 дугаарт бүртгэгдсэн “Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох журам”-ын 3.1.7. дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор төмөр замын тээвэр зуучийн үйл ажиллагаа эрхлэгчдийн цахим мэдээллийн санг бүрдүүлж ажиллах бөгөөд өөрийн вэб хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэй байлгана.

5. Төмөр замын тээвэр зуучийн үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээтэй холбоотой ямар нэгэн хураамж бусад мөнгөн хэлбэрийн зүйлийг шаардан авахгүй.
6. Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо нь цаашид салбарын эрх ашгийн төлөө хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаа сурталчилан таниулах замаар, сайн дурын үндсэн дээр нэгдэх зарчмыг үндэслэн 2016 оны эхний хагас жилд багтаан гишүүнчлэл, төлөөллийн цар хүрээгээ тэлж, төмөр замын тээвэр зуучлалын салбарын нийт оролцогчдын 70-аас доошгүй хувийг төлөөлөх нөхцөлийг хангана.
7. “Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо” ТББ нь тээврийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага /Зам, тээврийн яам/-ыг шаардлагатай бүх мэдээллээр хангана.
8. Санамж бичгийн протоколын хэрэгжилтийг “Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо” ТББ нь зөрчих, биелүүлэхгүй байх эсхүл аль нэг тал татгалзсан тохиолдолд энэхүү протоколыг цуцлана.


Энэхүү санамж бичгийг хэрэгжүүлэх протоколыг 2016 оны 01 дүгээр сарын ... -ны өдөр 2 хувь үйлдэв.

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ:



Б.АРТУР
ТЗДТБХЗГ-ЫН ДАРГА

“МОНГОЛЫН ТЭЭВЭР ЗУУЧЛАГЧДЫН
НЭГДСЭН ХОЛБОО” ТББ-ЫГ
ТӨЛӨӨЛЖ:



Б.ГАНЗОРИГ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ